

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 01 сарын 07-ны өдөр

№ 04/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх (цаашид "Захиалагч гэх"), нөгөө талаас Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ахлах багш, Доктор Э.Энхсайхан РД:ХЕ87070710 (цаашид "Ажил гүйцэтгэгч гэх") нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### 1. Нийтлэг заалт

- 1.1. Ажил гүйцэтгэгч нь захиалагчийн даалгаврын дагуу Амгалан Дулааны станц ТӨХК-ийг дулаанаар /1x116МВт/-аар өргөтгөхөд шаардагдах судалгаа, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг хугацаанд нь гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгнө.
- 1.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч, хөлсийг гэрээгээр тохиролцсон хэлбэр, хугацаанд төлнө.
- 1.3 Гэрээгээр гүйцэтгэх ажил нь гэрээний хавсралт байна. Хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### 2. Гэрээний хугацаа

- 2.1. Ажил гүйцэтгэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоох бөгөөд календарийн тооллыг удирдлага болгоно.
- 2.2. Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа: 40 хоног
- 2.3. Ажил эхлэх хугацаа: 2022-01-07
- 2.4. Ажил дуусах хугацаа: 2022-02-15

### 3. Ажлын хөлс

- 3.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 2 650 000 /хоёр сая зургаан зуун тавин мянга/-н төгрөг байна.
- 3.2. Ажлын үр дүнг бүрэн гүйцэтгэж, түүнийг хүлээлгэн өгөх үед хөлсийг төлнө.
- 3.3 Ажлын хөлсийг захиалагч нь ажил гүйцэтгэгч талын **Голомт банкны 1179218960** тоот дансанд шилжүүлнэ.

### 4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1. Ажил гүйцэтгэгч үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад мэдээллийг өгнө.
- 4.2. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 5 хоногын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авч хөлсийг саадгүй төлөх үүрэгтэй.
- 4.4 Ажлын гүйцэтгэлийг эрх бүхий байгууллагаар хянуулан, баталгаажуулж авах эрхтэй.

## **5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан бичиг баримт болон бусад мэдээллийг захиалагчид бүрэн, бүтэн буцааж хүлээлгэн өгнө.
- 5.4. Захиалагчийн өгсөн бичиг баримт болон мэдээлэл нь ажлын шаардлага хангахгүй бол түүнийг сольж өгөхийг шаардах эрхтэй.
- 5.5. Ажлын гүйцэтгэлийг эрх бүхий байгууллагаар хянуулан, баталгаажуулж захиалагч талд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

## **6. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,1 хувийн алданги төлнө.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

## **7. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлөлт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 7.2. Дээрхи давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

## **8. Бусад заалт**

- 8.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 8.3. Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

## **9. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам**

- 9.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

### 10. Нэмэлт нөхцөл

---

---

---

---

---

### 11. Гэрээ байгуулсан талуудын төлөөлөл:

БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ч.ЦОГТСАЙХАН

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ө.УДВАЛ

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА

Э.АРИУНБОЛД

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

### 12. Талуудын хаяг


#### Захиалгч:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг  
8-р хороо Ус 15-1-1  
Утас: 77111242

#### Ажил гүйцэтгэгч:

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг  
16-р хороо Туул 9-185 тоот  
Утас: 86078706



БАТЛАВ  
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР  ЦОГТСАЙХАН

Амгалан Дулааны Станц ТӨХК-ийг дулаанаар /1x116 МВт/-аар өргөтгөхөд  
шаардагдах судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах

ажлын эзэлхүүн

**Нэг. Төслийн үндэслэл**

- 1.1 Улаанбаатар хотын дулаан хангамжийн өнөөгийн байдал
- 1.2 Дулааны эрчим хүчний хэрэглээний өсөлтийн хандлага
- 1.3 “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн товч танилцуулга
- 1.4 “Амгалан дулааны станц” ТӨХК -ийн дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн төлөвлөлт, техникийн бодлогыг хэрэгжүүлэхэд мөрдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичгүүд
  - 1.4.1 Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын стратегийн зорилго, зорилтыг, хэрэгжүүлэх арга хэмжээ
  - 1.4.2 Техникийн бодлогыг хэрэгжүүлэхэд мөрдөж байгаа зарчим хууль, эрх зүйн баримт бичгүүд
  - 1.4.3 “Амгалан дулааны станц” ТӨХК -аас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн техник технологийн шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн үндсэн ажлууд

**Хоёр. Шинэ зуух суурилуулснаар эрсдэлийн түвшин ба найдвартай ажиллагаанд гарах өөрчлөлтгийн талаар хийсэн үнэлгээ, шинжилгээ**

- 2.1 Анхны төслийн дараа буюу QXF-116-1.6/130/70-АII маркын 3-н зуух үеийн дулааны балансын тооцоо
- 2.2 “Амгалан дулааны станц” ТӨХК -ийн сүүлийн 5 жилийн техник эдийн засгийн үзүүлэлтүүд, тэдгээрт хийсэн дүн шинжилгээ
- 2.3 Оргил ачааллын үеийн дулааны дээд ачаалал авах үеийн түлш, усны хэрэглээ
- 2.4 Дулааны станцын ус хангамжийн судалгаа, тооцоо
- 2.5 Эдийн засгийн шинжилгээ
  - 2.5.1 Төслийн нийт хөрөнгө оруулалт
  - 2.5.2 Эдийн засгийн үнэлгээ
  - 2.5.3 Бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц
  - 2.5.4 Хөрөнгө оруулалт
  - 2.5.5 Өртөг зардал
  - 2.5.6 Борлуулалтын орлого ба татвар
  - 2.5.7 Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн шинжилгээ
  - 2.5.8 Мэдрэмжийн шинжилгээ
- 2.6 Байгаль орчинд үзүүлэх нөлөө
  - 2.6.1 Ерөнхий зүйл
  - 2.6.2 Агаарт хаягдах бохирдуулагчийн ялгарал
  - 2.6.3 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил
  - 2.6.4 Шинээр суурилагдах зуух ашиглах үеийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээ
  - 2.6.5 Байгаль орчны бохирдлын хяналт
- 2.7 Хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн асуудал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийн менежмент

**Гурав. Шинээр суурилуулах зуухны тоноглолд тавигдах үндсэн шаардлага,**

## сонголт

- 3.1 Түлшний үндсэн үзүүлэлт
- 3.2 Тоноглолын хүчин чадлын сонголт, шийдэл
- 3.3 Зуухны хяналтын удирдлагын системийн шийдэл
- 3.4 Зуухны туслах тоноглолын цахилгаан хангамж
- 3.5 Реле хамгаалалт, автоматикийн байгууламжид тавигдах шаардлага
- 3.6 Зуух барихад үйлдвэрийн барилгыг өргөтгөх боломж

## Дөрөв. Туслах тоноглолуудын тооцоо, сонголт

- 4.1. Түлш дамжуулах тоноглолын хүчин чадлын тооцоо
  - 4.1.1 Бункер дүүргэлтийн судалгаа
  - 4.1.2 Нүүрс нөөцлөх ил талбайгаас нүүрс татах үеийн хүчин чадал
  - 4.1.3 Туслах тоноглолын цахилгаан хөдөлгүүрийн судалгаа
  - 4.1.4 Шинээр суурилагдах зуухны түүхий нүүрсний бункер
  - 4.1.5 Зуухыг дан Бөөрөлжүүтийн нүүрсээр хангах үеийн түлш дамжуулах цехэд үүсэх нөхцөл
- 4.2. Зуухны туслах тоноглолын сонголт
  - 4.2.1 Анхдагч ба хоёрдогч агаарын үлээх салхилуурын сонголт
  - 4.2.2 Буцаах салхилуурын сонголт
  - 4.2.3 Утаа сорогчийн сонголт
  - 4.2.4 Уутат шүүлтүүрийн сонголт
  - 4.2.5 Бутлуурын сонголт
- 4.3. Ус бэлтгэлийн системийн өөрчлөлт, нэмэлт усны тооцоо
- 4.4. Үнс зайлуулах системийн өөрчлөлт
- 4.5. Үнс хадгалах байгууламжийн тооцоо
- 4.6. Зуухны өргөтгөлийн хүрээнд шинээр СУН суурилуулж холбох тухай
- 4.7. Зуухны цахилгаан тоноглолын ачааллын тооцоо
- 4.8. Яндангийн тооцоо

## Тав. Төслийг хэрэгжүүлэх үйл явц, хүний нөөцийн бодлого

### Зургаа. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

### Ашигласан материалын жагсаалт

### Хавсралт

- Хавсралт 1. Станцын ерөнхий төлөвлөлтийн өөрчлөлтийн зураг.
- Хавсралт 2. ДС-ын хуучин компоновкаг авч оруулах.
- Хавсралт 3. Зуухны барилгын +0.0 тэмдэгтийн план
- Хавсралт 4. Зуухны барилгын +5.8 тэмдэгтийн план
- Хавсралт 5. Түлш дамжуулгын өөрчлөлт
- Хавсралт 6. Үнс зайлуулах системийн схем
- Хавсралт 7. Үнс хадгалах агуулах /Үнсний төслийн зураг төсөл/
- Хавсралт 8. Ус бэлтгэлийн системийн өөрчлөлт
- Хавсралт 9. Түлш дамжуулах

БОЛОВСРУУЛСАН:

ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА



Э.АРИУНБОЛД